



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар Зүүн Азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо ХК-ийн  
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/059/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга	Ч.Болд
	Утас: 7000-7734	Цахим хаяг: boldch@audit.gov.mn
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга	Х.Түвшинбаяр
Улаанбаатар хот 2025 он	Утас: 327734	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	С.Гантөгс
	Утас: 315558	Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Н.Бадамхатан
	Утас: 325093	Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

№ 03/14 № 01/300  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН  
ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГА,  
УЛААНБААТАР ЗҮҮН АЗИЙН  
ЗАЛУУЧУУДЫН НААДАМ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО  
ХК-ИЙН ТАТАН БУУЛГАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА  
В.ОЮУМАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар Зүүн Азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн ИТХ-ын 2024 оны 122 дугаар тогтоолоор “Нийслэлийн өмчит Улаанбаатар Зүүн Азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо” ХК-ийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан татан буулгах тухай” шийдвэр гаргасан байна.

### Аудитын гол асуудал

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 тогтоолын хавсралтаар УБЗАЗНЗБХ ХК-ийн 2024 оны төсвийн төлөвлөлтөд ажиллагсадтай холбоотой зардалд 263,888.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 148,132.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 54,879.1 мянган төгрөг, нийт 466,900.0 мянган төгрөгийн төсвийг баталсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна

C:\Users\zandime.#\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.03.14.ZAZNZB\Horo.docx

1425010130

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	776,652,952.37	
1.1.2	Дансны авлага	28,518,804.32	
1.1.6	Бараа материал	686,641,560.00	
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	453,673,602.00	
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,945,486,919</b>	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	463,279,277.91	
1.2.2	Биет бус хөрөнгө	9,075,504.19	
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>472,354,782.10</b>	-
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,417,841,700.79</u></b>	<b>-</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1.1.1	Дансны өглөг	38,172,774.46	
2.1.1.3	Татварын өр	68,550,765.44	
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>106,723,539.90</b>	-
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>106,723,539.90</b>	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	80,000.00	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,311,038,160.89	
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>2,311,118,160.89</b>	-
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,417,841,700.79</u></b>	<b>-</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Үзүүлэлт	Өмнөх он	/төгрөгөөр/
			Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	16,778,503,000.00	
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>16,778,503,000.00</b>	<b>-</b>
8	Бусад орлого	121,884,801.15	4,693,672.87
10	Ерөнхий ба удирдлагын зардал	13,335,193,107.98	1,429,231,503.80
12	Бусад зардал	1,730,320,255.28	29,316,407.86
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(3,035,430.56)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(1,232,075,265.25)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>1,834,874,437.89</b>	<b>(2,688,964,934.60)</b>
19	Орлогын татварын зардал		469,367.29
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	<b>1,834,874,437.89</b>	<b>(2,689,434,301.89)</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>1,834,874,437.89</b>	<b>(2,689,434,301.89)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>(25,740,702.11)</b>	<b>-</b>
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	(25,740,702.11)	-
<b>24</b>	<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>1,809,133,735.78</b>	<b>(2,689,434,301.89)</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээн ий нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	80,000.00	502,025,481.63	502,105,481.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(60,528.26)	(60,528.26)
<b>Залруулсан үлдэгдэл</b>			80,000.00	501,964,953.37	<b>502,044,953.37</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,809,073,207.52	<b>1,809,073,207.52</b>
Өмчид гарсан өөрчлөлт					-
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	80,000.00	2,311,038,160.89	2,311,118,160.89
<b>2024 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл</b>			80,000.00	2,311,038,160.89	2,311,118,160.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(80,000.00)	378,396,141.00	<b>378,316,141.00</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	-	-	2,689,434,301.89	<b>2,689,434,301.89</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,689,434,301.89)	<b>(2,689,434,301.89)</b>
Өмчид гарсан өөрчлөлт					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	-	-	-

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

1	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн	18,190,202,762.16	98,439,386.55
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	16,778,503,000.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,411,699,762.16	98,439,386.55
1.2	Мөнгөн зарлагын дүн	17,353,611,576.45	872,056,908.36
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,212,166,770.22	180,260,038.99
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	571,073,037.20	49,002,815.55
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	650,897,366.39	22,357,944.48
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	362,814,026.00	27,060,000.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	323,680,398.00	411,037.00
1.2.6	Шуудан холбоо, интернэтийн үйлчилгээний төлбөрт төлсөн		5,400,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	544,415,989.79	80,945,122.78
1.2.8	Албан томилолтын зардалд төлсөн		6,000,000.00
1.2.9	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс		111,370,290.96
1.2.10	Бусад мөнгөн зарлага	12,688,563,988.85	131,006,208.86
1.2.11	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	258,243,449.74
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>836,591,185.71</b>	<b>(773,617,521.81)</b>
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>117,824,900.00</b>	<b>-</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	117,824,900.00	
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(117,824,900.00)</b>	<b>-</b>
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(25,740,702.11)</b>	<b>(3,035,430.56)</b>
4	Валютын ханшийн зөрүү	(25,740,702.11)	(3,035,430.56)
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>693,025,583.60</b>	<b>(776,652,952.37)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>83,627,368.77</b>	<b>776,652,952.37</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>776,652,952.37</b>	<b>-</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 81,914.3 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		НББ-ийн үйл ажиллагааг буруу хэрэгжүүлсэн-тэй холбоотой		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа үйлчилгээний зардлыг мөнгөн гүйлгээний тайланд давхардуулан тайлагнасан.	1	81,914.3			1	81,914.3	1	81,914.3				
Дүн	1	81,914.3			1	81,914.3	1	81,914.3				

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,